



I-VI/2021


Тархаасан: 2021 оны 8 дугаар сарын 11



Төлбөрийн тэнцэл 2021 оны 6 дугаар сард 54.2 сая америк долларын алдагдалтай гарлаа

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 934.9 сая америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 52.2 (5.9%) сая америк доллароор өсжээ. Тус өсөлтөд анхдагч орлогын алдагдал өмнөх оны мөн үеэс 499.8 сая америк доллароор өсөж, 945.6 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна. Харин урсгал дансны алдагдал 2021 оны 6 дугаар сард 412.4 сая америк доллар болж, өмнөх сараас 268.9 сая америк доллароор өсжээ.

Зураг 1. Урсгал данс, сая америк доллароор, сараар



Үйлчилгээний худалдааны орлого 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 354.4 сая америк доллар, зарлага 822.1 сая америк доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 27.1 сая америк доллароор өсөж, зарлага 215.5 сая америк доллароор буурсан байна.

Хүснэгт 1. Үйлчилгээний худалдааны тэнцэл, салбараар

Үзүүлэлт	2020		2021*	
	VI	I-VI	VI	I-VI
	сая америк доллар			
Үйлчилгээ	- 105.4	- 710.3	- 90.6	- 467.6
Кредит	52.7	327.3	57.9	354.4
Дебит	158.1	1 037.6	148.6	822.1
Тээвэр	- 18.7	- 79.3	- 0.6	8.0
Кредит	30.4	190.8	40.6	244.6
Дебит	49.1	270.1	41.2	236.6
Аялал	- 32.0	- 304.2	- 42.0	- 273.9
Кредит	1.1	22.2	1.8	7.5
Дебит	33.2	326.4	43.8	281.4
Бусад үйлчилгээ	- 54.7	- 326.8	- 47.9	- 201.8
Кредит	21.1	114.3	15.6	102.3
Дебит	75.8	441.0	63.5	304.1

Хөрөнгийн данс 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 63.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 12.4 сая америк доллароор өссөн байна. Харин хөрөнгийн дансны ашиг 2021 оны 6 дугаар сард 7.0 сая америк доллар болж, өмнөх сараас 8.2 сая америк доллароор буурчээ.

Санхүүгийн дансны тэнцэл 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 768.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 349.4 сая америк доллароор өсжээ. Харин санхүүгийн дансны ашиг 2021 оны 6 дугаар сард 68.9 сая америк доллар болж, өмнөх сараас 60.9 сая америк доллароор буурчээ.

Хүснэгт 2. Төлбөрийн тэнцлийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2020		2021*		Төлбөрийн тэнцэл 2020 оны эхний хагас жилд 679.2 сая америк долларын алдагдалтай байсан бол 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр алдагдал өмнөх оны мөн үеэс 625.0 сая америк доллароор буурч, 54.2 сая америк долларын алдагдалтай байна. Мөн төлбөрийн тэнцэл 2021 оны 6 дугаар сард 285.8 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх сараас 272.4 сая америк доллароор өсжээ.
	VI	I-VI	VI	I-VI	
	сая америк доллар				
Урсгал данс	85.8	- 882.7	- 412.4	- 934.9	
Хөрөнгийн данс	8.7	51.2	7.0	63.6	
Санхүүгийн данс	- 422.8	- 419.2	- 68.9	- 768.6	
Алдаа болон орхигдуулга	- 65.6	- 266.9	50.7	48.5	
Нөөц хөрөнгө	451.8	- 679.2	- 285.8	- 54.2	

Ойлголт, тодорхойлолт:

Төлбөрийн тэнцэл: Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

Урсгал данс: Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

Хөрөнгийн данс: Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Санхүүгийн данс: Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед "+" буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед "-" буюу ашигтайг илэрхийлнэ.

Цэвэр нөөц: Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

Шууд хөрөнгө оруулалт: Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.



Эх үүсвэр: Монголбанк

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 9 дүгээр сарын 16

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн албаны
статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-261563

